

**ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн
2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН БАКАЛАВР ОЮУТНЫ ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ**

ЗОРИЛГО: Оюутан залуусын судалгааны ажлын ур чадварыг дээшлүүлэх, онолын мэдлэгийг бататгах, техник болон бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, судалгааны багийн ажиллагааг дэмжин, харилцан суралцахад оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ: ДаТС-ийн Бакалавр болон ахисан түвшинд суралцагч оюутнууд оролцоно.

Эрдэм шинжилгээний хурлын чиглэл:

- Салбар 1. Техник-технологи, байгалийн ухаан
- Салбар 2. Нийгэм, хүмүүнлэг, эдийн засаг менежмент

Жич: Судалгааны ажлын үр дүнд тодорхой бүтээл бий болсон бол давуу тал, үнэлгээ нэмэх үндэслэл болно.

Бакалавр оюутны илтгэл, өгүүллийг дараах үзүүлэлтүүдийн дагуу тус бүр 5 оноогоор дүгнэж шалгаруулна. Үүнд:

1. Шинэ санаа, шинэлэг шийдэл
2. Хэрэглээнд нэвтрүүлэх боломж, ач холбогдол
3. Судалгаа, туршилтад суурилсан үр дүн
4. Эдийн засгийн үр ашиг
5. Оюутны илтгэх ур чадвар, боловсруулалт /хугацаандаа илтгэсэн/

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үе шат	Зохион байгуулах ажил	Явагдах хугацаа	Хариуцах хүн	Тайлбар
1-р шат	Салбарын эрдэм шинжилгээний хурал	3-р сарын 1-7	Салбарын эрхлэгч нар Б.Басбиш Ч. Ганзориг Б.Уянгасайхан Б.Сувд-Эрдэнэ	<ul style="list-style-type: none">• Салбарын оюутны хурлын хөтөлбөрийг ЭНБД-аар 2023.03.07-ны дотор батлуулах.• Мэргэжил /хөтөлбөр/ бүрээс 2-оос доошгүй илтгэл орсон байх шаардлагатай бөгөөд нэг мэргэжлээс орох илтгэлийн нийт тоонд хязгаар тавихгүй.• Салбараас шалгарсан илтгэлүүдийг https://must.edu.mn/mn/esh_oguulel_zaaavar/ шаардлагын дагуу өгүүлэл хэлбэрт оруулан бичсэн байх• Салбараас шалгарсан илтгэлийн бичвэр-Өгүүлэл хүлээн авах хугацаа: 2024.03.12

2,3-р шат	Хурлын хөтөлбөр боловсруулан тараах	3-р сарын 13	Г.Ганчимэг /ЭШИА/	<ul style="list-style-type: none"> Оролцох илтгэлүүдийн сэдвийг 3-р сарын 12-ний өдөр ажлын цагт багтаан салбарын эрхлэгч нар Г.Ганчимэг /403 тоот/-т биеэр болон gan@stda.edu.mn цахим хаягаар (файлаар) өгсөн байх. Илтгэлийн РРТ файлуудыг 2024.03.13-ны ажлын цагт багтаан gan@stda.edu.mn хаягаар файлаар өгсөн байх. Илтгэх хугацаа 10 минут тул энэ хугацаанд багтаахаар илтгэлийн боловсруулалтыг төлөвлөхийг зөвлөж байна.
	ДаТС-ийн Бакалавр оюутны хурал	3-р сарын 14	ЭНБД Д.Баясгалан ЭШИА Г.Ганчимэг Оюутны зөвлөл	<ul style="list-style-type: none"> ✓ Салбар чиглэл бүрээс шалгарсан илтгэл, бүтээлүүд ШУТИС-ийн “ЭРДМИЙН 23 ДУГААР ЧУУЛГАН” болон Оюутны эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулах уралдаанд тус тус оролцоно.

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

I байр Өргөмжлөл, кредитийн урамшуулал

II байр Өргөмжлөл, кредитийн урамшуулал

III байр Өргөмжлөл, кредитийн урамшуулал

Илтгэл хэлэлцүүлсэн оюутнуудад батламж гардуулна.

Эрдэм шинжилгээний алба